

**"ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ" ОНӨААТҮГ-ЫН
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд erp.ulaanbaatar.mn дотоод удирдлагын нэгдсэн системийг нэвтрүүлсэнтэй холбогдуулан тус байгууллага иргэд, өөрсдийн ажилтан, ажиллагсдаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг дээрх нэгдсэн системийн өргөдөл, гомдлын дэд системд бүртгэн шийдвэрлэж байна.

Тус байгууллагад 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагаар 495 өргөдөл, хүсэлт, санал бүртгэгдсэн ба байгууллагын өргөдөл гомдол хүлээн авах утсанд өргөдөл, гомдолгүй ажилласан.

Тайлант хугацаанд нийт 495 өргөдөл, хүсэлт ирснээс 99% хугацаандаа шийдвэрлэсэн, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 2 өргөдөл, гомдол байна.

Нийт шийдвэрлэсэн өргөдөл, хүсэлтийн 495 буюу 99 хувьтай шийдвэрлэсэн бөгөөд өргөдлийн дундаж хугацаа нь 8 хоног 17 цаг 17 минутад шийдвэрлэсэн байна.

Ирсэн өргөдөл, хүсэлтийн хариу өгсөн хэлбэрийг ангилбал: Программ хангамж+Мессеж + Утсаар хариу өгсөн 495, Программ хангамж + Мессежээр хариу өгсөн 3, Программ хангамж + Мессеж + Албан бичгээр хариу өгсөн 0, Иргэнтэй биеэр уулзаж хариу хүргүүлсэн 9, боломжгүй тухай хариу өгсөн өргөдөл 0, иргэний талд шийдвэрлэсэн өргөдөл 495 өргөдөл, хүсэлт байна.

Бүртгэгдсэн өргөдөл, хүсэлтийг хандалтаар нь ангилбал:

Д/д	Ангилал	Өргөдөл, гомдлын тоо	Өргөдөл гомдлын хувь
1	Ажилд орох тухай	143	28,89%
2	Ажлаас чөлөөлөгдөх тухай	91	18.38%
3	Ажилд шилжих, дэвшин ажиллах тухай	52	10,51%
4	Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай	27	5,45%
5	Цалинтай чөлөө хүсэх тухай	35	7,07%
6	Цалингүй чөлөө хүсэх тухай	25	5.05%
7	Цалин, хөлсний тухай	3	0.61%
8	Жирэмсний амралтын тухай	1	0.20%
9	Боловсролын байгууллагын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн тухай	0	0.00%

10	Нийтийн тээврийн салбарын үйл ажиллагааны тухай	1	0.20%
11	Сургалтанд хамрагдах тухай	0	0.00%
12	Нийт өргөдөл, гомдлын дүн	495	100.00%

№	Өргөдлийн төрөл	Тоо	Хувь
1	Хүсэлт	495	99,98%
2	Гомдол	1	0,02%
3	Санал	-	0,0%
Дүн		216	100,0%

Нийт ирсэн 495 өргөдөл, хүсэлт бүгд тус байгууллагын Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэст хувиарлагдан бүртгэгдэж, шийдвэрлэсэн байна.

Зөрчлийн тоон үзүүлэлтийг харуулбал:


Д/д	Зөрчлийн төрөл	Зөрчлийн тоо
1	Өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил	6
2	Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчлийн тоо	20
3	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил	119
Нийт		145

Холбогдох албан хаагч нар нь явцын тэмдэглэлийг өргөдөл хүсэлт ирсэн даруйд хөтөлсөн боловч өргөдөл хүсэлт шийдвэрлэлтийн хугацаандаа байх 10 хоног тутам явцын тэмдэглэлийг дахин хөтлөөгүй зөрчилгүй байна.

ДҮГНЭЛТ:


Epr.ulaanbaatar.mn нэгдсэн удирдлагын системд бүртгэлтэй ажилтан, албан хаагчдыг иргэдээс ирсэн өргөдөл, гомдол, албан бичгийн шийдвэрлэлтийн хугацааг богиносгох, зөрчлийн тоон үзүүлэлт, төрлийг багасгах, шийдвэрлэлтийн явцад зөрчил гаргасан албан хаагчид цаашид зөрчил гаргахгүй байхыг анхааруулж, биелэлтэд удирдлагуудын зүгээс хяналт тавин ажиллаж байна.

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:
БҮТЭЭМЖИЙН МЕНЕЖЕР



Д.ЭНХЖАРГАЛ

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:
БИЧИГ ХЭРЭГ, ӨРГӨДӨЛ ГОМДОЛ
ХАРИУЦСАН АЖИЛТАН



Д.ХАНДМАА